*Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 225 дугаар тогтоолоор баталсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 4 дүгээр хавсралт*

Жилийн үйл ажиллагааны тайлагнал /маягт 1/

*Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.*

| | |
|---|---|
| *Тайлагнах хугацаа /Жишээ нь: 2020 оны 1 дүгээр сарын 01- ний өдрөөс 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр/* | *2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр* |
| *Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар* | *"ТЭЭВЭР ДАРХАН" ХК<br>УБГД: 000064033<br>ҮЦКод:217<br>Утасны дугаар: 976-70374126* |
| *Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр* | *Монголын Хөрөнгийн Бирж ХК* |
| *Бизнесийн үйл ажиллагааны салбар* | *721 - Зах ажиллуулж, ажлын байр түрээслүүлэх* |
| *Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо* | *"Бэйкер Тилли Далайван Аудит" ХХК,* |
| *Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг* | *163349ширхэг* |
| *Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр* | *Бэлтгэсэн: Ерөнхий нягтлан бодогч Д.Бямбажаргал<br>Хянасан: Гүйцэтгэх захирал М.Оюун* |

1\. *Тайлант жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/*

| | Үзүүлэлт | 1/1/2025 | 12/31/2025 |
|---|---|---|---|
| *Санхүүгийн байдлын үзүүлэлт* | **ХӨРӨНГӨ** | | |
| | Эргэлтийн хөрөнгө | 756,052,542.33 | 3,902,222,122.99 |
| | Эргэлтийн бус хөрөнгө | 2,984,280,724.75 | 2,832,060,698.35 |
| | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **3,740,333,267.08** | **6,734,282,821.34** |
| | **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ** | | |
| | Богино хугацаат өр төлбөр | 792,447,038.76 | 3,595,166,582.31 |
| | Урт хугацаат өр төлбөр | | |
| | Эздийн өмчийн дүн | 2,947,886,228.32 | 3,139,116,239.03 |
| | **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ** | **3,740,333,267.08** | **6,734,282,821.34** |
| *Орлогын тайлан* | **Үзүүлэлт** | **1/1/2025** | **12/31/2025** |
| | Борлуулалтын орлого (цэвэр) | 4,538,068,695.41 | 5,676,072,947.84 |
| | Борлуулалтын өртөг | 3,875,572,083.28 | 4,618,475,216.49 |
| | Нийт ашиг (алдагдал) | 662,496,612.13 | 1,057,597,731.35 |
| | **Татвар төлөхийн өмнөх ашиг (ашиг алдагдал)** | **(129,137,062.61)** | **(222,682,984.12)** |
| | Орлогын татварын зардал | - | 31,452,973.41 |
| | **Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)** | **(129,137,062.61)** | **191,230,010.71** |
| | Бусад дэлгэрэнгүй орлого | | |
| | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү | | |
| | Орлогын нийт дүн | **(129,137,062.61)** | **191,230,010.71** |

| | Үзүүлэлт | 1/1/2025 | 12/31/2025 |
|---|---|---|---|
| *Өмчийн өөрчлөлтийн тайлан* | Өмч | 16,334,900.00 | 16,334,900.00 |
| | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | 1,844,088,054.82 | 1,844,088,054.82 |
| | Эздийн өмчийн бусад хэсэг | | |
| | Хуримтлагдсан ашиг | 1,087,463,273.50 | 1,278,693,284.21 |
| | Нийт эздийн өмчийн дүн | **2,947,886,228.32** | **3,139,116,239.03** |

| | Үзүүлэлт | 1/1/2025 | 12/31/2025 |
|---|---|---|---|
| *Мөнгөн гүйлгээний тайлан* | Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | (175,376,270.97) | (257.089.243.22) |
| | Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр Мөнгөн гүйлгээний дүн | (106,733,557.57) | (2,513,044,919.00) |
| | Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн Гүйлгээ | (269,007,571.03) | (2,775,390,605.62) |
| | Бүх цэвэр мөнгөн гүйлгээ | **(13,102,257.51)** | **5,256,443.40** |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний Үлдэгдэл | 24,122,410.15 | 11,020,152.64 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн Эцсийн үлдэгдэл | **11,020,152.64** | **16,276,596.04** |

*1.1. Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт*

***ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН***

***"ТЭЭВЭР ДАРХАН" ХК-ИЙН***
***ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД***

***Дүгнэлт***

*Бид 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн "Тээвэр Дархан" ХК-ийн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.*

*Бидний дүгнэлтээр "Тээвэр Дархан" ХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн үйл ажиллагааны орлого үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартад нийцүүлэн Сангийн сайдаас баталсан санхүүгийн тайлан гаргах, нягтлан бодох бүртгэл хөтлөх заавар, журам, аргачлалын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байна.*

***Дүгнэлтийн үндэслэл***

*Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Энэ стандартын дагуу бидний хүлээх үүрэг хариуцлагыг энэхүү тайлангийн санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан. Бид нягтлан бодогчдын Ёс зүйн олон улсын стандартын зөвлөлийн Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм (Хараат бус байдлын олон улсын стандартыг багтаасан)-н дагуу компаниас хараат бус байж, эдгээр ёс зүйн шаардлагууд, НБЁЗОУСЗ-ийн дүрэмд нийцсэн ёс зүйн бусад үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно.*

*Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудиторын санал дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой гэж бид үзэж байна.*

*1.2. Аудитын тодорхойлох захидал /тодорхойлох захидлыг энэхүү зааварт дурдсан агуулгын хүрээнд боловсруулсан байх/*

*Компанийн үйл ажиллагааг цаашид тасралтгүй явуулахад компанийн хувьцаа эзэмшигчид болон төлөөлөн удирдах зөвлөл анхаарч ажиллах шаардлагатай байна.*

| | | |
|---|---|---|
| 2. | *Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан, мэдээлэл* | |
| 2.1. | *Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/* | *Нийт ашгийн хувь 18.6%*<br>*Эздийн өмчийн өгөөж /ROE/ 6.09%*<br>*Нийт хөрөнгийн өгөөж /ROA/ 2.83%* |
| 2.2. | *Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц боломжийн үзүүлэлт* | *Эргэлтийн харьцаа 108.5*<br>*Түргэн хөрвөх чадварын харьцаа 37.39*<br>*Өр болон өөрийн хөрөнгийн харьцаа 7.9* |
| 2.3. | *Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл* | *Гадаад орчны нөлөөлөл байхгүй байна.* |
| 2.4. | *Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/* | *Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил гүйлгээ байхгүй* |
| 2.5. | *Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл;* | *2025.05.20-нд авсан зээл 2 тэрбум 700 сая төгрөг, эргэн төлөлт сар бүрийн 25-нд 73850,0 мянган төгрөг төлдөг.* |
| 3. | *Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/* | |

| | |
|---|---|
| | *Манай компанийн толгой буюу хараат компани болох "Монгол Алт" ХК-ийн хэрэгжүүлж байгаа орон сууцны барилгын төслийг банкны зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлэх зорилгоор манай компани өөрийн эзэмшлийн үл хөдлөх хөрөнгийг бизнесийн үйл ажиллагааг нь дэмжих зорилгоор "Хаан банк" ХК-иас зээл авах, компанийн эзэмшилд буй үл хөдлөх хөрөнгүүдийг барьцаалуулах зөвшөөрөл олгосон.*<br>*Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 377 дугаар тогтоолоор баталсан "Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам"-ын 2.3, 2.10 дахь хэсэгт тус тус заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцүүлэхээр зарлаж, хурал хуралдуулах шийдвэр гарсан өдрөөс хойш 40-өөс доошгүй хоногийн дараа хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах зохицуулалттай байдаг. Энэ дагуу "Тээвэр Дархан" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл 2025 оны 12 сарын 18-ны өдөр хуралдан хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаа 2026 оны 01 сарын 28-ны өдөр зарлан хуралдуулсан.*<br>*Тэгээд Их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох тухай санал хураалтын дүнгээр Компанийн тухай хуулийн 92 дугаар зүйлийн 92.3, "Тээвэр дархан" ХК -ийн хувьцаа эзэмшигчдийн 2026 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн ээлжит бус хурлын тооллогын комисс компанийн их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох тухай асуудлыг хэлэлцсэн санал хураалтын дүнг тус тус үндэслэн Сонирхлын зөрчилгүй хувьцаа эзэмшигчдийн санал хураалтын дүнгээр: Зөвшөөрсөн 1786 санал 100 хувийн саналаар зөвшөөрсөн тогтоол гарч баталсан.* |

| | |
|---|---|
| 4. | *Цалин урамшууллын мэдээлэл* |
| | *Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13, "Тээвэр Дархан" Хувьцаат компанийн дүрмийн 7.8 дугаар зүйлийн 7.8.7 болон тус компанийн хувьцаа эзэмшигчдийн 2026 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын 02 тоот тогтоолыг тус тус үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас:*<br>*"Тээвэр Дархан" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хэвийн үйл ажиллагаа хангах 2026 оны зардлын төсвийг 15,720,000 төгрөгөөр тогтоосон.* |
| 5. | *Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл* |
| | ***ТУЗ-ийн үүрэг***<br>*Төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн үйл ажиллагааны үр дүнтэй холбогдуулан хувьцаа эзэмшигчдийн өмнө хариуцлага хүлээдэг.*<br>*ТУЗ гүйцэтгэх захирлын ажлын үр дүнг үнэлэх, дүгнэх томилох, дотоод хяналт, эрсдлийн удирлага, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянах зэрэг үүрэгтэй.*<br><br>***ТУЗ-ийн хороод***<br>*"Тээвэр Дархан" ХК ТУЗ-өөс даалгасан тодорхой үүрэг хариуцлага бүхий байнгын 3 хороотой ба эдгээр хороод нь ТУЗ-ийн шийдвэр гаргах үйл ажиллагаанд дэмжлэг болгох зорилгоор санал дүгнэлт гаргах үндсэн зорилготой. Хороодын үйл ажиллагааг "Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журам"-аар зохицуулдаг.*<br><br>*ТУЗ нь дараах байнгын хороодтой:*<br>• *Нэр дэвшүүлэх хороо*<br>• *Аудитын хороо*<br>• *Цалин, урамшууллын хороо*<br>ТУЗ –ийн гишүүн нь нэгээс дээш хороонд ажиллаж болно. Компанийн тухай хуульд ТУЗ-ийн хараат бус гишүүн нь аудитын хороонд ажиллахаар заасан байдаг.<br>*"Тээвэр Дархан" ХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн 02 тоот тогтоолын дагуу "Тээвэр Дархан" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зохион байгуулсан.*<br>*ТУЗ-ийн дарга:*<br>*Ж.Очирсүх /"Дархан Брокер" ХХК ХОС-ын дарга /*<br>*ТУЗ-ийн ердийн гишүүд:*<br>*М.Оюун / "Тээвэр Дархан" ХК-ний Гүйцэтгэх захирал /*<br>*Ж.Мөнхтөр / "Монгол Алт" ХК-ийн Зөвлөх /*<br>*Л.Амарсанаа / "Газопровод Соёз Восток" ХХК Төслийн зохицуулагч /*<br>*М.Жавхлан / "Авани Ти Эм" ХХК-ийн Гүйцэтгэх захирал /*<br>*Б.Саруул / "Монгол Алт" ХК барилгын аж ахуйн нярав /*<br>*ТУЗ-ийн хараат бус гишүүд:*<br>*Л.Чулуун / тэтгэвэрт /*<br>*Д.Бумцэрэн /тэтгэвэрт/*<br>*Х.Жаргалсайхан /тэтгэвэрт/*<br>*ТУЗ-ийн нарийн бичгийн дарга:*<br>*ТУЗ үйл ажиллагаагаа хэвийн явуулах, хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захирал болон бусад оролцогч талуудын хоорондын үйл ажиллагааны уялдааг хангах зорилгоор ТУЗ-д шууд хариуцлага хүлээх нарийн бичгийн даргыг томилох үүрэгтэй. Компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар компанийн ХНМ хавсран ажиллаж байна.* |
| 6. | *Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл* |
| | - |
| 7. | *Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс эзэмшлийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо/* |

| | |
|---|---|
| | *Толгой компани болох "Монгол Алт ХК" 83758ш буюу 51%*<br>*Хувьцаа эзэмшигч Минээ Оюун 25418ш буюу 15,7%*<br>*Хувьцаа эзэмшигч Жамбал Мөнхтөр 34380ш буюу 21,04%*<br>*Хувьцаа эзэмшигч Мөнхтөр Цолмон 5022ш буюу 3,07%*<br>*Хувьцаа эзэмшигч Лувсандагва Амарсанаа 7722ш буюу 4,7%*<br>*Нийт Хувьцааны тоо ширхэг 163349, Хувьцаа эзэмшигчдийн тоо 57.* |
| *8.* | *Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл* |
| | - |
| *9.* | *Ногдол ашгийн мэдээлэл* |
| | *ТУЗ-ийн 2026 оны 02 дугаар сарын 16ны өдрийн тогтоолоор, Ногдол ашиг хуваарилна гэсний дагуу ХЭХ-ын 2026.04.27-ны Ээлжит хуралд оролцогч хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналаар нэгж хувьцаанд оногдох ногдол ашгийг 500 төгрөгөөр олгохоор;*<br>*Ногдол ашгийг 2026 оны 12-р сарын 31-ний дотор олгохоор тогтоосон.* |
| *10.* | *Үнэт цаас гаргагчаас тайланд хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл* |
| | - |

*МХБ Төлөөлөн удирдах зөвлөлийн*
*2024 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн*
*47 дугаар тогтоолын хавсралт*
*"Үнэт цаас гаргагчаас олон нийтэд хүргэх мэдээллийн журам"*

| | |
|---|---|
| *11.* | *Үнэт цаас гаргагчийн бүтэц (толгой, охин, хараат, зэргэлдээ компаниуд, тэдгээрийн хувь эзэмшлийн талаар), холбоотой талуудын санхүүгийн гүйлгээний талаарх мэдээлэл;* |
| | *Толгой компани болох "Монгол Алт" ХК, эзэмшдэг хувь 51%* |
| *12.* | *Үнэт цаас гаргагч нь (Банк, Даатгал, Банк бус санхүүгийн байгууллага, болон Үнэт цаасны компани) төлбөрийн чадвар, зохистой харьцааны шалгуур үзүүлэлт* |
| | |
| *13.* | *Үнэт цаас гаргагч нь өөрийн гаргасан хувьцааг эргүүлэн худалдан авч, хүчингүй болгох замаар хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг бууруулах, компанийн алдагдал тухайн тайлант үеийн эзэмшигчийн өөрийн хөрөнгийн 30 хувиас хэтрэх, компанийн өр нь хоёр жил дараалан өөрийн хөрөнгөөс илүү болж, хасах утгатай болох нөхцөл байдал үүсэхээс урьдчилан сэргийлж, энэхүү нөхцөл байдал үүссэн тохиолдолд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар мэдээлэл* |
| | - |
| *14.* | *Тайлант хугацаанд эргүүлэн худалдан авсан халаасны хувьцааны тоо, ширхэг, ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр хэрэгжүүлсэн, үнэт цаасаар урамшуулал олгосон талаарх мэдээлэл* |
| | - |